



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2015.04.15 № 4/98

Зөрчлийг арилгах тухай

Үндэсний аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын 2014 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

1. Тусгай газар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11.2.1-т заасан хугацаанд жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг явуулсан боловч хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулаагүй, хөрөнгийн тооллогын дүн нь санхүүгийн тайлангаар гарсан үлдэгдэлийн дүнтэй зөрүүтэй тайлагнагдсан байна. Тухайлбал: Балансын дүнгээс тоног төхөөрөмжийн дүн 3,4 сая төгрөгөөр илүү, тавилга эд хогшлын дүн 8,8 сая төгрөгөөр дутуу тус тус зөрүүтэй, тооллогын дүнг албан ёсоор хэлэлцэж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Тээвэр, шатахуун, төлбөр хураамж, гадаад албан томилолт, сургалт семинар, мэдээлэл сурталчилгаанд зарцуулсан зарим баримтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь тус газрын дотоод хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаатай холбоотой байна. Тухайлбал: Дээр дурдсан зардлуудтай холбоотой зарим ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад нийт 20,7 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Байгууллагын 2014 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс эд хөрөнгийн тооллогын зөрүүг дахин нарийвчлан үзэж, тооллогыг чанаргүй хийсэн холбогдох хүмүүстэй хариуцлага тооцож, тооллогын дүнг баталгаажуулж, баримтжуулах, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахгүй байх шаардлагатай байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дээр дурдсан зөрчлийг арилгаж,

гүйцэтгэлийг гарган 2015 оны 8 дугаар сарын 1-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус газрын Ерөнхий нягтлан бодогч Б.Бямбасүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Ц.ЦЭРЭНХҮҮ

Handwritten notes in Mongolian script, possibly a date and time, located in the bottom right corner of the page.